

БАТЛАВ.
АЙМГИЙН БТС-ИЙН ГАЗРЫН
ДАРГА Д.АЛТАНХУЯГ

БАТЛАВ
АЙМГИЙН ВОЛЕЙБОЛЫН ХОЛБООНЫ
ТЭРГҮҮН Д.БААТАР

**АЙМГИЙН ВОЛЕЙБОЛЫН ХОЛБООНЫ НЭРЭМЖИТ
НАСАНД ХҮРЭГЧДИЙН АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ВОЛЕЙБОЛЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

2019.11.11

Зуунмод

ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО:

Волейболын спортыг сурталчилах, тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, волейболын спортод дур сонирхолтой болгох, харилцан туршлага солилцох, чадварлаг тамирчид төрүүлэн гаргахад оршино.

ТЭМЦЭЭНИЙХУГАЦАА:

Тэмцээн 2019 оны 11-р сарын 29-нөөс 12 сарын 01-ны өдрүүдэд Төв аймгийн Зуунмод суманд явагдана.

ТЭМЦЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

- Тэмцээнийг аймгийн БТС-ын Газар, Аймгийн Волейболын холбоо, Төв аймгийн Нутгийн Залуучуудын клуб хамтран зохион байгуулна.
- Тэмцээнд оролцох мандатыг 2019.11.28-ны 15⁰⁰ цагт олгоно.
- Тэмцээний техникийн зөвлөгөөнийг 2019 оны 11-р сарын 28-ны 17⁰⁰ цагт **БТСГ-т хийнэ.**
- Тэмцээний нээлтийн үйл ажиллагаа 2019 оны 11-р сарын 29-ны 12⁰⁰ цагт “**БТСГ**”-т болно.

БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХҮНИЙ ТОО:

- Тэмцээнд нэг сум байгууллагаас хэдэн ч баг оролцохыг зөвшөөрнө. Баг 8 хүний бүрэлдэхүүнтэй оролцоно. Багт ЕБС-ийн 1-2 тамирчин оролцохыг зөвшөөрнө.
- Тэмцээнд Төв аймгийн харьяалалтай тамирчид оролцоно
- Тэмцээн 2 насны ангилалаар явагдана. Эрэгтэй 18-аас дээш, 50-аас дээш, эмэгтэй 18-аас дээш, 45-аас дээш

ТАМИРЧДЫН БҮРДҮҮЛЖ ИРЭХ БИЧИГ БАРИМТ:

- Иргэний үнэмлэх
- Сурагчийн хувийн хэрэг
- 1% цээж зураг
- Эрхийн төлбөр / Тамирчин тус бүр 3000 төгрөг/
- Мэдүүлэг албан ёсны тамга тэмдэгтэй баталгаажсан байх

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

Эрэгтэй, эмэгтэй тамирчид тус бүр /насны ангилал тус бүрээр/

- 1-р байр – Цом, алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал
- 2-р байр – Мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал
- 3-р байр – Хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал
- Шилдэг довтлогч, шилдэг холбогч, тэгш тоглогчдыг шалгаруулна

ТАЙЛБАР:

1. Тэмцээнд оролцох багууд дүрмийн шаардлага хангасан тоглолтын жигд хувцастай байна.
2. Тэмцээнд оролцох тамирчдын аюулгүй байдлыг хангасан унаа тэргээр ирэх
3. Тамирчдын байр, хоол, унааны зардлыг тухайн сум, албан байгууллага хариуцана.

**Аймгийн БТС-ын газар
Аймгийн Волейболын холбоо**

БАТЛАВ
АЙМГИЙН ШАГАЙН ХАРВААНЫ
ХОЛБООНЫ ТЭРГҮҮН Д. ЦОЛМОН

ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН УУГУУЛ МОНГОЛ УЛСЫН
“ГАРАМГАЙ МЭРГЭН” МОНГОЛ УЛСЫН “ХАРЫШГҮЙ МЭРГЭН”
СУНДУЙЖАВЫН ГАЛБАДРАХ АГСАНЫ НЭРЭМЖИТ
ТӨВ АЙМГИЙН “ОТГО ХАРВАА” ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

2019.10.30

Зуунмод

Нэг Зорилго

Монголын үндэсний уламжлалт шагайн харвааг өргөн дэлгэр хөгжүүлэх, ахмад харваачдаас залуу үед уламжлалт ёс жаягыг өвлүүлэх, харваачдын ур чадврыг дээшлүүлэхэд оршино

Хоёр. Тэмцээн явагдах газар хугцаа

Тэмцээн 2019 оны 11 дүгээр сарын 09-нд 9⁰⁰ цагаас Аймгийн БТС-ын Газрын спорт зааланд болно. Тэмцээн Монголын шагайн харвааны холбооны V хурлаар батлагдсан дүрмийн дагуу явагдана. Тэмцээнийг Аймгийн БТС-ын Газар, Төв аймгийн Шагайн харвааны салбар холбоо хамтран зохион байгуулна.

Гурав. Тэмцээн явагдах журам

Тэмцээнд аль ч аймаг, хот, сумын баг харваачид оролцож болно. Тэмцээнд оролцож буй баг тамирчид Монгол үндэсний дээл хувцастай оролцоно. Тэмцээн багийн болон ахмадын /зөвхөн хуруугаар харвадаг/ хурууны багийн гэсэн ангилалаар явагдана. Бууны багийг оролцуулахгүй. Тэмцээн МШХХолбооны дүрмын дагуу өрж тоглоно. Багийн эрхийн төлбөр 20.000 төгрөг.

Дөрөв. Шагнал урамшил

Багийн харваанд эхний 4 байрт шалгарсан багийг алт, мөнгө, хүрэл медаль өргөмжлөл мөнгөн шагналаар, 5, 6-р байр эзэлсэн багийг мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

Ахмадын хурууны багийг эхний 4 байр эзэлүүлж алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

Холбоо барих утас: 99794599

Аймгийн шагайн харвааны холбоо

БАТЛАВ
АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН
ДАРГА **Д.АЛТАНХУЯГ**

УИХ-ЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, БАТЛАН
ХАМГААЛАХЫН САЙД Н.ЭНХБОЛДЫН НЭРЭМЖИТ “АТАРЧИН-2019”
СПОРТЫН НААДМЫН ЗААВАР

2019-11-11

Зуунмод

Нэг. Зорилго:

Монгол улсын Засгийн Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн Газрын 2018 оны 76 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол улсад Атар газар эзэмшсэний 60-н жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, биеийн тамир спортоор хичээллэх иргэдийн хүрээг нэмэгдүүлэх, спортын наадмыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцуулахад оршино.

Хоёр. Тэмцээний зохион байгуулалт, явуулах хугацаа:

“Атарчин-2019” спортын наадмыг 2019 оны 11-р сарын 23-24-нд Зуунмод суманд Аймгийн ЗДТГазар, Аймгийн БТС-ын Газар, Спортын холбоод хамтран зохион байгуулна. Тэмцээнийг Аймгийн БТС-ын Газар, спортын холбоодоос томилогдсон шүүгчдийн бүрэлдэхүүн зохион байгуулж явуулна. 2019 оны 11-р сарын 21-ны 14.00-18.00 цагт мандат олгож, 18.00 цагаас техникийн зөвлөгөөнийг Аймгийн БТС-ын Газрын хурлын танхимд хийнэ.

Гурав. Спортын төрөл, багийн бүрэлдэхүүн:

1. Волейбол эр 8, эм 8 /нэг багт ЕБС-ийн 1 сурагч орохыг зөвшөөрнө./Нэг сумаас эрэгтэй 1 эмэгтэй 1 баг оролцоно.
 2. Ширээний теннис эр 1, эм 1
 3. Шатар эр 1, эм 1
 4. Үндэсний бөх /сумаас 2 залуу бөх /
 5. Шагайн харваа эр 8 хүнтэй баг оролцоно
- Тэмцээнд зөвхөн Төв аймгийн харьяат насанд хүрэгчид /18-аас дээш насны/ оролцоно.

Дөрөв. Бүрдүүлэх бичиг баримт:

1. Иргэний үнэмлэх
2. 3 х 4 хэмжээтэй 1 % цээж зураг
3. Багийн мэдүүлэг /Албан ёсны тамга тэмдэгтэй баталгаажсан байна/
4. Эрхийн төлбөр 3000 төгрөг

Тав. Шагнал урамшил:

Тэмцээний төрөл тус бүрд 1, 2, 3-р байр эзэлсэн баг тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар, байгууллагын нэгдсэн дүнгээр 1-р байр эзэлсэн сумыг цом, өргөмжлөл, спортын хэрэглэл материалаар, 2, 3-р байр эзэлсэн сумдыг өргөмжлөл, спортын хэрэглэл материалаар шагнана.

Зургаа. Төсөв зардал:

Тэмцээнд оролцох тамирчдын байр, хоол, унааны зардлыг тухайн сум, албан байгууллага хариуцана.

Долоо. Анхаарах зүйл:

1. Тэмцээнд оролцох баг тамирчид тоглолтын дүрмийн шаардлага хангасан жигд хувцас формтой, бөхийн өмсгөл, шагайн харваа үндэсний дээл хувцастай байна.
2. Волейболын тэмцээнд оролцох ЕБС-ийн сурагчид заавал иргэний үнэмлэхтэй байна. Мандатын материал дутуу, хоцорч ирсэн тамирчид тэмцээнд оролцох боломжгүй болохыг анхааруулж байна.
3. Багийн дүнг бүх төрөлд оролцсон тохиолдолд гаргана.
4. Тэмцээнд оролцох урьдчилсан мэдүүлэгээ 11-р сарын 21-ны дотор 95758361, 99794599 утсаар мэдэгдэнэ үү.

Тэмцээн зохион байгуулах комисс

**МОНГОЛ УЛСАД АТАР ГАЗАР ЭЗЭМШСЭНИЙ 60-Н ЖИЛИЙН ОЙН
ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ УИХ-ЫН ГИШҮҮН,
БАТЛАХ ХАМГААЛАХЫН САЙД Н.ЭНХБОЛДЫН НЭРЭМЖИТ
“ АТАРЧИН-2019” СПОРТЫН НААДМЫН
ТӨСӨВ ЗАРДАЛ**

2019-11-04

Зуунмод

| № | Юунд зарцуулах | 1-р байр | 2-р байр | 3-р байр | Бүгд дүн |
|----|---------------------------------|---|--------------------------|--------------------------|-------------------------|
| 1 | Волейбол /эр 8, эм 8 / | 16 х 25.000 = 400.000 | 16 х 20.000 = 320.000 | 16 х 15.000 = 240.000 | 960.000 |
| 2 | Ширээний теннис /эр1, эм 1/ | 2 х 25.000 = 50.000 | 2 х 20.000 = 40.000 | 2 х 15.000 = 30.000 | 120.000 |
| 3 | Шатар /эр1, эм 1/ | 2 х 25.000 = 50.000 | 2 х 20.000 = 40.000 | 2 х 15.000 = 30.000 | 120.000 |
| 4 | Шагайн харваа /баг 8 хүнтэй/ | 8 х 25.000 = 200.000 | 8 х 20.000 = 160.000 | 8 х 15.000 = 120.000 | 480.000 |
| 5 | Үндэсний бөх | 100.000 | 80.000 | 2 х 50.000 = 100.00 | 280.000 |
| 6 | Өргөмжлөл | Жаазтай 9 ш х 15.000 = 135.000 Жижиг 84 ш х 3000 = 246.000 | | | 408.000 |
| 7 | Медаль | 88 ш х 8.000 | | | 704.000 |
| 8 | Анос | | | | 100.000 |
| 9 | Багийн шагнал | 500.000 | 400.000 | 300.000 | 1.200.000 |
| 10 | Шүүгчдийн зардал | 15 хүн х 2 хоног х 40.000 | | | 1.200.000 |
| 11 | Шилдэг тамирчдын шагнал | Төрөл тус бүр 10 хүн х 50.000 | | | 500.000 |
| 12 | Цом | 1 ш х 50.000 1 ш х 30.000 х 2 ш = 60.000 | | | 110.000 |
| | | Нийлбэр дүн | | | 6.182.000 төгрөг |

Төсөв хийсэн
Нарийн бичиг Д.Энхцэцэг

БАТЛАВ
АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН
ДАРГА

БАТЛАВ.
АЙМГИЙН АХМАД МАСТЕРУУДЫН
ХОЛБООНЫ ТЭРГҮҮН Га.ЛХАГВАСҮРЭН

АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ АХМАД
САГСАН БӨМБӨГЧДИЙН ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

2019-10-28

Зуунмод

Нэг. Зорилго:

Сагсан бөмбөгийн спортыг сурталчилан, хөгжүүлэх, ахмад тамирчдыг алдаршуулах, тэднээс суралцах, амжилтыг нь өсвөр үеийнхэнд таниуулах.

Хоёр. Тэмцээний зохион байгуулалт, хугацаа:

Тэмцээн 2019 оны 11-р сарын 02-03-ны өдөр Аймгийн БТС-ын Газрын спорт зааланд явагдана.Тэмцээнийг аймгийн БТС-ын Газар, Аймгийн ахмад мастеруудын холбоо хамтран зохион байгуулна.Тоглолтын системийг техникийн зөвлөгөөн дээр шийдвэрлэнэ.

Гурав. Багийн бүрэлдэхүүн, нас, хүний тоо:

Тэмцээнд сум, аж ахуйн нэгж, байгууллагаас хэдэн ч баг оролцож болно.Багийн бүрэлдэхүүн 8 хүнтэй байна.

Насны ангилал:

Эрэгтэй: 40-44 нас, 45-49 нас, 50-аас дээш нас

Эмэгтэй: 40-45 нас 46 – аас дээш нас

Дөрөв. Мандат олгох техникийн зөвлөгөөн

Тэмцээний техникийн зөвлөгөөнийг 2019 оны 11-р сарын 02-ны өдрийн 8.30 цагт БТС-ны Газрын сургалтын танхимд хийнэ.Тэмцээн 9.00 цагаас эхэлнэ.Тэмцээнд оролцох баг тамирчид:

1. Албан ёсны мэдүүлэг
2. Иргэний үнэмлэх
3. Зураг 1 %
4. Эрхийн төлбөр 50.000 төгрөг /багийн/

Тав. Шагнал урамшил:

Тэмцээнд 1-р байр эзэлсэн багуудыг цом, алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, 2, 3-р байр эзэлсэн багуудыг мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

Жич: Тамирчид тоглолтын жигд хувцастай ар, өврийн номертой байна. Тэмцээнд оролцох тамирчид байр, хоол, унааны зардлыг өөрсдөө хариуцана.Тэмцээнд зөвхөн Төв аймгийн харьяат хүн оролцоно.

Харилцах утас: 95758361

Аймгийн БТС-ын Газар

**"ТӨВ АЙМГИЙН ДАРТСЫН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН 2019" –НИЙ УДИРДАМЖ**

Зорилго:

Монголын дартсын спортын тамирчдын ур чадвар болон Дартсын спортын хөгжил идэвхитэй байгаа энэ үед, Төв аймгийн ард иргэдийн дунд энэхүү спортын ач холбогдлыг ойлгуулж, нутгийн тамирчидыг төрүүлэн гаргах, залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, дартсын спортын гайхамшгийг таниулах, шинэ залуу тамирчдыг төрүүлэх, спортын давуу талыг нийтэд таниулан ач холбогдлыг сурталчилах, дартсын клубүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэн нэмэгдүүлэхэд гол зорилго нь оршино.

2. Хамрах хүрээ:

Дартсын спортоор хичээллэдэг, сонирхогч Төв аймгийн харъяат 16-с дээш насны хүн бүрт нээлттэй

3.Тэмцээн ерөнхий зохион байгуулагч:

Монголын Дартс Сонирхогчдын Холбоо

4.Хамтран зохион байгуулагч:

Төв аймгийн Засаг Даргын Тамгын Газар,
Төв аймгийн Биеийн Тамир Спортын Газар,
Төв аймгийн Төв телевиз
Төв аймгийн Төв+ залуучуудын байгууллага
Төв аймгийн Монгол Ардын Намын Хороо

5. Тэмцээний төрөл болон хураамж:

- Багийн төрөл /2 эрэгтэй 1 эмэгтэй /
- Хураамж - 30000₮

6. Тэмцээний журам:

Баг нь 3 хүнтэй байна./эрэгтэй 2, эмэгтэй 1/ багт заавал эмэгтэй хүн байх ёстой.Багууд 4-8 хэсэгт сугалаагаар хуваагдаж хэсэгтээ тойргоор тоглоно.Хэсгээс хожлын оноогоор эхний 2 баг шалгарч цааш хасагдах системээр аваргын төлөө өрсөлдөх болно.

1-р байрын төлөөх тоглолт түрүүлж 4 хожилоор, 3-р байрын төлөөх тоглолт 3 хожилоор тоглох бол хэсгийн тоглолтууд 2 хожлоор хасагдах шатны тоглолтууд бүгд түрүүлж 3 хожлоор явагдана.

7. Шагнал

- 1-р байр Медаль, Өргөмжлөл, 500.000 ₮
- 2-р байр Медаль, Өргөмжлөл, 300.000 ₮
- 3-р байр Медаль, Өргөмжлөл, 200.000₮
- 4-р байр Өргөмжлөл, 100.000₮
- 5-8-р шагналт байр Өргөмжлөл,4 х 30,000₮ =120.000₮

Цөөн сумны гараа , өндөр онооны гараа, 180 оноог хамгийн олон удаа авсан тамирчин тусгай шагналтай.

8. Тэмцээн зохион байгуулах өдөр, байршил:

Төв аймгийн Монгол Туургатан Театрт 2019 оны 11-р сарын 16-ны өдөр Бямба гарагт 10⁰⁰ цагаас эхэлнэ.

9. Тэмцээний мэдүүлэг хаагдах хугацаа: 2019.11.11 ны 20 цаг

10. Тоглолтын дүрэм:

- Тоглолт төрөл хамаарахгүйгээр 501 онооноос эхэлнэ.
- Тоглолтыг хоёрын үржвэрээр тэглэж дуусгана.
- Өрсөлдөгч нар шодож хэн түрүүлж буханд шидэхээ шийдвэрлэх бөгөөд самбарын төвд хэн ойр сумаа шидсэн нь тоглолтыг эхлүүлнэ.
- Хэрэв өрсөлдөгч нарын хожлын харьцаа тэнцвэл сүүлчийн шийдвэрлэх тоглолтыг тоглолтын дарааллын дагуу явуулна.
- Тамирчид шүүгч болон өрсөлдөгчдөө оноогоо гүйцэт харуулсны дараа сумаа самбараас авна. Хэрэв гүйцэт харуулалгүйгээр сумаа авсан тохиолдолд авсан 3 сумны нийлбэр оноог тооцохгүй
- Самбараас сум авах үед унасан сумны тоог оноонд тооцох бөгөөд самбарт гар хүрэхээс өмнө унасан сумны оноог оноонд тооцохгүй.
- Хэрэв сум ар араасаа давхралдан зоогдсон тохиолдолд зөвхөн эхний сумны оноогоор тооцно.
- Хэрэв 2 сумны хооронд сум орж тогтоод сумны үзүүр самбартаа хүрсэн бол үзүүр хүрсэн оноог тооцно.
- Эрэгтэй, эмэгтэй анхан болон дунд шатны тэмцээнд өрсөлдөгч нар 45 суманд багтаан тоглолтоо дуусгаагүй тохиолдолд дүрмийн дагуу бухруу шидэж хожлыг шийдвэрлэнэ.
- Хэсгийн тоглолтын оноог чанараар буюу (+-) н зөрүүгээр тооцно.
- Шидэлт гүйцэтгэсэн тамирчид самбараас сумаа авч өрсөлдөгчрүүгээ харалгүй баруун талаар нь гарч өрсөлдөгчдөө саад болохооргүйгээр зайтай зогсох ёстой.

*Сугалаа хийх үед ирээгүй тамирчдын сугалааг зохион байгуулагч талаас хийнэ.
Тамирчдыг зарлаад 10 мин ирээгүй бол тухайн тоглолтыг “0” оноогоор буюу хожигдсонд тооцоно.*

11. Хувцаслалт:

Тамирчин бүр өөрийн болон байгууллагынхаа онцлогийг илтгэсэн хувцастай байх. Малгай, урт түрүүтэй болон өндөр өсгийтэй гутал зэргийг тоглолтонд өмсөхийг хатуу хориглоно.

Тэмцээнд оролцогчид олон улсын тэмцээний журмын дагуу хар өмд, хар өнгийн гутал өмссөн байхыг зөвлөж байна.

ХОЛБОГДОХ УТАС: 94043567, 91999692...

ХААН БАНК: 5064988942 Монголын Дартс Сонирхогчдын Холбоо

ТА БҮХЭНДЭЭ СПОРТЫН ӨНДӨР
АМЖИЛТ ХҮСЬЕ

**МОНГОЛ УЛСАД АТАР ГАЗАР ЭЗЭМШСЭНИЙ 60-Н ЖИЛИЙН ОЙН
ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ АХМАД ВОЛЕЙБОЛЧДЫН
АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

2019.10.09

Зуунмод

ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО:

Атар газар эзэмшсэний 60-н жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, волейболын спортыг сурталчилах, тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, тариаланчдыг волейболын спортод дур сонирхолтой болгох, ахмад тамирчдаас харилцан туршлага солилцох, чадварлаг тамирчдыг төрүүлэн гаргахад оршино.

ТЭМЦЭЭНИЙ ХУГАЦАА:

Тэмцээн 2019 оны 10 сарын 19-20 -ны өдрүүдэд Төв аймгийн Угтаалцайдам суманд явагдана.

ТЭМЦЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

- Тэмцээнийг аймгийн БТСГазар, Угтаалцайдам сумын ЗДТГ, Аймгийн ИТХ-ын төлөөлөгч аймгийн МАН-ын бүлгийн дарга Ц.Энхболд нар хамтран зохион байгуулна.
- Тэмцээнд оролцох мандатыг 2019.10.18-ны 19⁰⁰ цагт олгоно.
- Тэмцээний техникийн зөвлөгөөн 2019 оны 10 сарын 18ны 20⁰⁰ цагт Угтаалцайдам сумын Соёлын төвд болно.
- Тэмцээн 2019.10.19-ны 09⁰⁰ цагт эхэлнэ
- Тэмцээний нээлтийн үйл ажиллагаа 2019.10.19-ны 12⁰⁰ цагт сумын Соёлын төвийн “*Спортын зааланд*”-д эхэлнэ.

БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХҮНИЙ ТОО:

- Тэмцээн 35-45 нас, 46-аас дээш насны ангилалаар зохион байгуулагдана.
- Тэмцээнд сумаас 8 хүний бүрэлдэхүүнтэй, нас тус бүрт эрэгтэй, эмэгтэй баг оролцоно.

ТАМИРЧДЫН БҮРДҮҮЛЖ ИРЭХ БИЧИГ БАРИМТ:

- Иргэний үнэмлэх/Эх хувиараа/
- 1% цээж зураг
- Эрхийн төлбөр / Тамирчин тус бүр 5000 төгрөг/
- Мэдүүлэг албан ёсны баталгаатай байх

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

- Эрэгтэй, эмэгтэй тамирчид тус бүр /насны ангилал тус бүрээр/
- 1-р байр – алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал
 - 2-р байр – мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал
 - 3-р байр – хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал
 - Шилдэг тоглогч – 1 шалгаруулна

ТАЙЛБАР:

4. Мандатыг материалгүй, бичиг баримтын зөрчилтэй тамирчдад олгохгүй, тэмцээнд оруулахгүй болно.
5. Тэмцээнд оролцох багууд дүрмийн шаардлага хангасан тоглолтын жигд хувцастай байна.
6. Тэмцээнд оролцох тамирчдын аюулгүй байдлыг хангасан унаа тэргээр ирэх
7. Тамирчдын байр, хоол, унааны зардлыг тухайн сум, албан байгууллага хариуцана.
8. Тус тэмцээнд сум бүр идэвхитэй оролцох
9. Тэмцээний талаар лавлах утас: 90330477

Аймгийн БТС-ын Газар
Угтаалцайдам сумын ЗДТГазар

Аймгийн ИТХ-ын төлөөлөгч
Төв аймгийн МАН-ын бүлгийн дарга Ц.Энхболд

ҮНДЭСНИЙ БӨХИЙН ЛИГИЙН ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

“Дүнжингаравын цом-2019” үндэсний бөхийн лигийн барилдаанд оролцогч бөхчүүд шилжилт хөдөлгөөнийг цэгцтэй болгох, тэмцээнд оролцогч багийн эзэд болон дасгалжуулагч нар баг тамирчдаа бүрдүүлэх, сонгох, солилцоо наймаанд оруулах, тэмцээний ёс зүй, баримтлах дүрэм зэрэг бүхий л харилцааг энэхүү журмаар зохицуулахад оршино.

Хугацаа:

“Дүнжингаравын цом-2019” үндэсний бөхийн лигийн барилдаан нь жилд хоёр удаа (намар, хавар) зохион байгуулагдах ба намар 10-11 сар, хавар 5-6 сар дуустал үргэлжилнэ.

Хамрах хүрээ:

“Дүнжингаравын цом-2019” үндэсний бөхийн лигт Төв аймгийн харьяат болон аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгжид тогтвор суурьшилтай ажиллаж буй бөхчүүд оролцож болно.

Зохион байгуулалт:

“Дүнжингаравын цом-2019” үндэсний бөхийн лигт оролцож буй баг тус бүр оноосон нэр, багийн лого, билэгдэлтэй байх бөгөөд лигийн ерөнхий логог өөрийн багийн логотой хоршуулан тэмцээнд оролцоно. Баг тус бүр 10-15 тамирчинтай байна.

Тэмцээнд бүртгүүлэх, хураамж:

“Дүнжингаравын цом-2019” үндэсний бөхийн лигт оролцож буй баг тус бүр улирлын хураамж болох 1,500,000 төгрөгийг тушаах үүрэгтэй. /ХААН банкны тоот

“Төв аймгийн Үндэсний бөхийн холбооны дансанд шилжүүлнэ/

Шагнал:

“Дүнжингаравын цом-2019” үндэсний бөхийн лигийн барилдаанд оролцож буй багуудын хураамжаас шалтгаалан шагналын сан тодорхойлогдоно.

Хоёр. Барилдааны дүрэм

1. Лигийн улирлын барилдаанд эзэн болон зочин багийн 9 бөх хоорондоо барилдана.
2. Барилдааны хуваарийг зохион байгуулагчдын зүгээс улирал эхлэхээс өмнө гаргана. Хэрэв өөрчлөлт орвол дор хаяж 2 өдрийн өмнө мэдэгдэх бөгөөд бөхчүүд барилдаан эхлэх цагт бэлэн байх ёстой.
3. Багт ЕБС-ийн 3 сурагч байж болно. Тэдний 2 нь хоорондоо барилдах бөгөөд Монголын үндэсний бөхийн дүрмийн дагуу барилдана.
4. Барилдаан эхлэг үед багийн дасгалжуулагч барилдах 9 бөхийн нэрийг өгнө.
5. Багийн мэдүүлэгт 10-15 бөх байх ёстой ба хамгийн багадаа 9 бөх барилдааны өмнө бэлэн байх ёстой. Харин 9 бөх ирэхгүй тохиолдолд бүрэн бөхтэй багт шууд давааг өгнө.
6. Хоцорсон тохиолдолд 10 минут тавьж, ирээгүй тохиолдолд эсрэг багт хожлыг өгнө. Хэрэв хоёр баг хоёулаа заасан хугацаанд ирээгүй тохиолдолд илүү олон тоглогч ирсэн багт хожлыг өгнө.
7. Лигийн нээлт, хүмүүнлэгийн ажил болон нэгдсэн зохион байгуулалттай ажлууд лиг үргэлжлэх хугацаанд зохион байгуулагдана.
8. Мэдүүлгийг нэг л удаа өгөх бөгөөд ямар нэгэн засвар оруулах, бөх нэмж оруулахыг хориглоно. Бөхчүүд, дасгалжуулагчийн цээж зураг, иргэний үнэмлэхний хуулбарыг заавал хавсарган зохион байгуулах комисст өгнө.
9. Шигшээ барилдаанд түрүүлж хоёр хожсон баг дараагийн шатанд шалгарч аварга баг тодорно. Аваргын төлөөх тоглолт түрүүлж хоёр хожил авсан баг түрүүлэх зарчмаар шийдэгдэх бол, хүрэл медалийн тоглолт ГАНЦ барилдаанаар шийдэгдэнэ.

10. Ёс Зүйн алдаа авсан бөхийг 20,000 төгрөгөөр, баг тоглолтыг орхих болон ёс зүйн алдаа гаргавал 50.000 төгрөгөөр торгох бөгөөд дараагийн барилдаанд оролцохоос өмнө торгуулийг төлсөн байх шаардлагатай.
11. Шүүгч болон өрсөлдөгч бөхийнхөө биед халдсан, ёс зүйгүй авирласан, үгээр доромжилсон тохиолдолд 2 буюу түүнээс дээш барилдаанд оролцуулахгүй, Сахилгын Хорооны хурлаар асуудлыг оруулж, зохих шийтгэлийг онооно.
12. Сахилгын хороог лигт оролцож буй баг бүрээс 1 хүн, шүүгч 1, зохион байгуулагчдаас тодорхой тооны хүн нэмэгдэн орж сондгой тооны гишүүдтэй байгуулна. Комиссар санал өгөх эрхгүйгээр нэмэлт гишүүн болно. Хэрвээ сахилгын хорооны баг эсвэл ашиг сонирхлын зөрчил гарвал комиссар санал өгөх эрхтэй болно.

Танилцуулсан:

Танилцсан: Багийн төлөөлөл:

Зохион байгуулагч:

/
_____/ /
/
/
/

Багийн нэр:

Багийн ахлагч: _____ /

Багийн дасгалжуулагч: _____ /

Багийн эзэн (менежер): _____ /

Зохион байгуулах комисс

ДАРХАН АВАРГА Ж.МӨНХБАТЫН НЭРЭМЖИТ 2019 ОНЫ
ӨСВӨР ҮЕИЙН АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ҮНДЭСНИЙ БӨХИЙН ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР.

2019-08-16

Зуунмод

Нэг. Ерөнхий зүйл:

1. Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах үндэсний бөхийн барилдаан 2019 оны 09-р сарын 27-29-ны өдрүүдэд Төв аймгийн Зуунмод суманд болно.
2. Барилдааныг 14-15, 16, 17, 18 гэсэн 4 насны ангилалаар зохион байгуулана.
3. Тэмцээний 14-15 насанд 2004-2005 онд төрсөн хөвгүүд барилдана.
16 насанд 2002.10.01-нээс 2003.10.01-ний хооронд төрсөн хөвгүүд
17 насанд 2001.10.01-нээс 2002.10.01-ний хооронд төрсөн хөвгүүд
18 насанд 2000.10.01-нээс 2001.10.01-ний хооронд төрсөн хөвгүүд тус тус барилдана
4. 27 сум 31 сургуулиас шалгарсан нас тус бүрд 2 бөх оролцоно.
5. 15 насны ангилалд төрсний гэрчилгээ, эрүүл мэндийн даатгалын дэвтэр, сурагчийн хувийн хэрэгтэй байна.Бусад насны ангилалд зөвхөн иргэний цахим үнэмлэхээр бүртгэнэ.
6. Баг тамирчид албан ёсны зурагтай мэдүүлэг, 1 % цээж зураг, эрхийн төлбөр 2500 төгрөгийг авч ирнэ.
7. Бөхчүүдийг 2019 оны 09-р сарын 27-ны өдөр 15⁰⁰ – 19⁰⁰ цагийн хооронд бүртгэж мандат олгон техникийн зөвлөгөөнийг хийнэ. Тэмцээн 2019 оны 09-р сарын 28-ны өдрийн 9⁰⁰ цагаас эхэлнэ.

Хоёр. Барилдаан зохион явуулах аргачлал:

1. Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг тойргийн журмаар явуулна.Тодруулбал сумдаас шалгарсан бөхчүүд нас тус бүрдээ тойргоор барилдаж дүнг гаргана.
2. Багийн дүнг гаргахдаа бага онооны системийг хэрэглэнэ. Энэ нь нас тус бүрт барилдсан бөхийн эзэлсэн байрын нийлбэр хамгийн бага байхыг гол үзүүлэлт болгох систем юм.Хэрэв энэ үзүүлэлт ижил гарвал дараах үзүүлэлтүүдийг ээлж дараалан харгалзах журмаар зохих байрыг тодруулна.

Үүнд:

- Бөхийн давааны оноо
- Эзэлсэн байрын чанар
- Хамгийн бага насанд эзэлсэн байрыг тус тус харгалзана.

Харин аль нэг насанд бөх оролцуулаагүй бол тэр багт /насанд нь / хамгийн их оноог өгч байрыг эзэлүүлнэ.

Жич: Тэмцээнд оролцох байр, хоол, унааны зардлыг тухайн байгууллага өөрсдөө хариуцана.

Холбоо барих утас: 80015858 дасгалжуулагч Л.Энхбаяр

Аймгийн БТС-ын газар

АХМАД ТАМИРЧИН Ц.БАТТӨМӨР, Р.БАТАА НАРЫН НЭРЭМЖИТ ШИРЭЭНИЙ
ТЕННИСНИЙ АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

2019.05.15

Зуунмод

Нэг. Зорилго:

Ширээний теннисний спортыг хөдөө орон нутагт хөгжүүлэх, ахмад тамирчдыг алдаршуулах, өсвөр үеийнхэнд тэднийг таниулах, тамирчдын ур чадварыг ахиулахад оршино.

Хоёр. Тэмцээний зохион байгуулалт, явуулах хугацаа:

Тэмцээнийг 2019 оны 05-р сарын 18-19-ны өдрүүдэд Төв аймгийн Баянчандмань суманд зохион байгуулагдана. Тэмцээнийг Төв аймгийн БТС-ын Газар, Баянчандмань сумын ЗДТГазар, МСҮТөв хамтран зохион байгуулна.

Гурав. Тэмцээн зохион байгуулагдах насны ангилал :

Ахмад багш Ц.Баттөмөр, Р.Батаа багш нарын нэрэмжит насанд хүрэгчид, ахмадын ширээний теннисний аварга шалгаруулах тэмцээн дараах насны ангилалаар явагдана.

1. 18 – 39 нас: эрэгтэй, эмэгтэй
2. 40 – 49 нас: эрэгтэй, эмэгтэй
3. 50-аас дээш нас эрэгтэй, эмэгтэй гэсэн ангилалаар явагдана.

Дөрөв. Шагнал урамшуулал :

Тэмцээнд 1, 2, 3-р байр эзэлсэн тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

Тав. Төсөв зардал :

Тэмцээнд оролцох сум, аж ахуйн нэгж , байгууллагын тамирчдын байр , хоол , унааны зардлыг тухайн байгууллага хариуцна.

ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОМИСС

2019.04.03

Зуунмод

**“ОЛИМПИЙН ТУГИЙН АЯНЫ ХЭМЖЭЭНД, ОЛИМПИЙН БОЛОВСРОЛ
БА БИЕ БЯЛДРЫН ХҮМҮҮЖИЛ” СЭДЭВТ БОЛЗОЛТ УРАЛДААНЫ ЗОХИОН
БАЙГУУЛЖ ЯВУУЛАХ АЯНЫ УДИРДАМЖ.**

Нэг.Нийтлэг үндэслэл

Монгол улсын биеийн тамир спортын болон олимпийн хөдөлгөөний хөгжил улам бүр эрчимжихийн зэрэгцээ, эдгээр хөдөлгөөний зорилго зорилт агуулга хэлбэрийг боловсоргүй болгох асуудал зүй ёсоор тавигдах боллоо. Ялангуяа өсвөр үеийхний бие бялдрын өв тэгш хөгжлийг хангах тэдэнд олимпийн соёл, үнэт зүйл ба олимпийн боловсрол хүмүүжлийг эзэмшүүлэх асуулал чухал, ач холбогдолтой болоод байна.

Аймгийн олимпийн зөвлөл, Биеийн тамир спортын газраас олимпийн боловсролыг түгээх дэлгэрүүлэх, өсвөр үеийхэнд эзэмшүүлж, түүнийг бие бялдрын хүмүүжлийн чиглэлийн үйл ажиллагаатай нягт уялдуулан зангидах чиглэлээр тодорхой ажиллуудыг тогтмол зохион байгуулж сумдын ерөнхий боловсролын сургуулиуд дахь олимпийн танхимуудаар дамжуулан хэрэгжүүлж буй нь бодит үр дүнгээ өгч байгаа юм.

МҮОХороо, МҮО-ийн акедемаас 2018 онд орон даяар, зохион байгуулсан “Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдааныг зохион байгуулахад манай аймгийн ЕБСургууль, Олимпийн танхимууд идэвхитэй оролцсон, олимпийн боловсрол, ба бие бялдрын хүмүүжлийн ажлын агуулга хэлбэрийг боловсронгуй болгох ажилд ахиц дэвшлийг бий болгоход бид талархалтай байна. Гэсэн хэдий ч ЕБС-ийн сурагчдын болон өсвөр үеийн хүүхдийн бие бялдрын хөгжилт бэлтгэлжилтийн түвшинг дээшлүүлэх олимпийн боловсрол олгох ажлын агуулга хэлбэрийг боловсронгуй болгох чанар үр дүнг нь бодитойгоор нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Дээрх асуудлаар боловсролын болон биеийн тамир спортын байгууллагууд Монголын үндэсний олимпийн хорооны хамтын үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байгаа билээ.

Энэхүү байдлыг харгалзан МҮОХороо, МҮОАкадемаас хамтран улсын хэмжээний ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Олимпийн боловсрол ба бие бялдрын хүмүүжил”сэдэвт болзолт уралдааныг зохион байгуулж явуулах удирдамжийг ирүүлсэн юм.

Болзолт уралдааныг зохион байгуулах үйл ажиллагааг БТСГазар, БСУ-ын газар, Аймаг дүүргүүдийн Олимпийн зөвлөл хамтран хэрэгжүүлнэ гэсний дагуу, БТСГазар, БСУГ-р Аймагийн олимпийн зөвлөл хамтран удирдан зохион байгуулна.

Хоёр: “Олимпийн боловсрол ба бие бялдын хүмүүжил” сэдэвт болзолт уралдааны зорилго хугацаа хамрах хүрээ

“Олимпийн боловсрол ба бие бялдарын хүмүүжил” сэдэвт болзолт уралдааны зорилго нь өсвөр үеийнхэнд олимпийн соёл, түүх үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлэх олимпийн боловсрол ба хүмүүжлийг эзэмшүүлэх эдгээрээр дамжуулан бие бялдарын өв тэгш хөгжлийг хангах авьяас чадварыг нь нээн илрүүлэх олимпийн танхимуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох биеийн тамирын багш нарын бүтээлч идэвхи санаачлага болон хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэхэд оршино.

Болзолт уралдаан доорхи зорилтуудыг шийдвэрлэнэ.

Үүнд:

1. Аймагийн БТС-ын газар, БСГ-ар, Олимпийн зөвлөл, ЕБС-луудын хамтын ажиллагааны уялдаа холбоог нэмэгдүүлэх, түүний үр дүнг дээшлүүлэх.

2. Сурагчдад олимпийн боловсрол олгох ажлын агуулга хэлбэр ба үр дүн ач холбогдлыг нэмэгдүүлэх

3. Ерөнхий боловсролын сургуулиудын олимпийн танхимуудын үйл ажиллагааг чанаржуулах боловсронгуй болгох

4. Биеийн тамирын хичээлийн чанар үр дүнг дээшлүүлэх ба бие бялдарын хүмүүжлийн ажлын тогтолцоог боловсронгуй болгох

5. Сургуулийн олимпийн танхимын зөвлөлийн дарга, арга зүй багш биеийн тамирын багш нарын хөдөлмөрийг үнэлэх ба бүтээлч идэвхи санаачлага ажлын хариуцлагыг дээшлүүлэх

Болзолт уралдааныг Аймагийн хэмжээнд 2019-04-10-2019-11-01-ны өдрийг хүртлэх хугацаанд зохион байгуулна. Тус арга хэмжээнд Аймагийн хэмжээний ерөнхий боловсролын бүх сургууль тэдгээрт үйл ажиллагаа явуулж буй олимпийн танхимууд оролцоно.

Гурав: Болзолт уралдааны зохион байгуулалт ба шагнал урамшил

- Аймагийн хэмжээнд Биеийн тамир спортын газар, Боловсрол соёл урлагийн газартай олимпийн зөвлөл хамтран ажиллаж болзолт уралдааныг зохион байгуулна.
- Сум сургуулийн олимпийн танхимын зөвлөлийн дарга (захирал) болзолт уралдааныг зохион байгуулах ажлын хэсгийг 3-5 хүнтэй байгуулж сургууль болон Олимпийн танхимууд доорхи чиглэлийн үйл ажиллагаа арга хэмжээнүүдийг зохион байгуулна.

Үүнд:

1. Олимпийн танхимаа шинэлэг байдлаар шинэчлэн тохижуулж олимпийн боловсрол олгох үр дүнтэй хэрэглүүр болгосон байх

2. Олимпийн хөдөлгөөний түүх олимпийн боловсрол сэдэвээр бага дунд ахлах ангийн сурагчид багш ажилтан албан хаагчдын дунд сургуулийн хэмжээнд тодорхой шинэлэг ажлуудыг зохион байгуулах

3. Сургуулийн хэмжээнд 6 дугаар сарын 22-нд “Олимпийн өдөр” зохион байгуулж төрөл бүрийн арга хэмжээ зохион байнуулах

- Гар зургийн уралдааныг бага ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулах
- Шүлэг, эссэ бичлэгийн уралдааныг ахлах дунд ангийн сурагчдын дунд зохион байгуулах
- Танин мэдэхүйн асуулт, хариултын АХА тэмцээнийг зохион байгуулах
- Олимпийн болон биеийн тамир спортын алдартнуудтай уулзалт хийж нэрэмжит уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулах
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд бие бялдрын хөгжилтийг өв тэгш олгох зорилт тавиж ажиллах
- Эцэг эхчүүдийг олимпийн хөдөлгөөнд татан оролцуулж хамтран ажиллах
- Олимпийн боловсрол олгох хичээлийг анги бүлэг бүрт заах
- Спорт олимпийн сэдэвээр ханын сонины уралдааныг тогтмол гаргадаг байх
- Олимпийн түүхэн бичлэгийн цуглуулагтай болж сурагчдад үзүүлж олимпизмыг сурталчлах
- Өв тэгш сурагч, шилдэг тамирчдын талаар сурталчлах мэдээлэлтэй болгох

Хичээлээс гадуур зохиогдох би бялдрын хүмүүжлийн ажлын чиглэлээр

Сургуулийн хэмжээнд 10-аас доошгүй спортын төрлөөр уралдаан тэмцээн зохион байгуулах

Орон нутагтаа хөгжүүлэх боломжтой спортын төрлөөр секц дугуйлан хичээллүүлж, Аймаг бүс улсын аварга шалгаруулах тэмцээнд баг тамирчдаа оролцуулах

Сургуулийн хэмжээнд биеийн тамирын материаллаг баазыг бэхжүүлж Спортын заал биеийн тамирын талбайгаа стандартын дагуу тохижуулж орчин нөхцлийг дээшлүүлсэн байх

Болзолт уралдааны явцад удирдамжид зааснаас гадна шинэлэг ажлууд болон янз бүрийн арга хэмжээнүүдийг өөрсдөө санаачлан зохион байгуулж хийх хэрэгтэй

Биеийн тамирын хичээлийн чанар үр дүнг дээшлүүлэх арга хэмжээ авсан байх

